



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН

20
20



ГОЛОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ

Тайлангийн тухай

Тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох стратегийн үндсэн чиглэлийн хүрээнд уг тайланг бэлтгэлээ.

Энэхүү тайлангаар 2020 онд Голомт банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд гадагшаа болон банкны дотоод үйл ажиллагаандаа хийж, хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнг харуулсан болно.

3

Та тайлан болон хэрэгжүүлсэн ажлуутдтай холбоотой асуулт, санал зөвлөмж байвал sustainablefinance@golomtbank.com хаягаар бидэнтэй холбогдоорой. Мөн Голомт банкны Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй сүүлийн үеийн ажлуутдтай танилцахыг хүсвэл www.golomtbank.com/ Банкны тухай/Тогтвортой хөгжил хэсгээс үзэх боломжтой.

Агуулга

МЭНДЧИЛГЭЭ

06-07

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

БИЗНЕС СТРАТЕГИ

08-11

- Бидний бизнес
- Нийгэм дэх бидний оролцоо
- Тогтвортой хөгжлийн стратегийн чиглэл

тогтвортой
хөгжлийн
тайлан
2020



Тогтвортой хөгжил гэдэг нь өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээг хязгаарлахгүй байх явдал юм.

Эдийн засгийг хөгжүүлэхээс гадна байгалийн нөөцийг үр ашигтайгаар зарцуулж, эрүүл мэнд, нийгмийн асуудлуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулах нь тогтвортой хөгжиж буйн илрэл юм.

ТОГТВОРТОЙ БИЗНЕС



12-23

- Тогтвортой санхүүжилт
- Ногоон зээл
- Жендерийн тэгш байдал
- Хамтын ажиллагаа
- Харилцагчийн санхүүгийн аюулгүй байдал

НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИН



24-31

- Байгальд ээлтэй бизнес
- Боловсролд чиглэсэн үйл ажиллагаа
- Эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа
- Соёлын өвийг хамгаалахуй

ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР



32-40

- Сэтгэл ханамжтай ажлын байр
- Тогтвортой санхүүжилтийн чадавх бэхжүүлэх сургалт
- Байгалийн нөөцийн зохистой хэрэглээ

5

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЖИЛТ, ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



41-43

- 2020 оны Тогтвортой хөгжлийн ололт амжилтууд
- 2021 оны Тогтвортой хөгжлийн үндсэн төлөвлөгөө

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Бид бодлого болон бизнесийн үйл ажиллагааг нийгмийн хэрэгцээтэй уялдуулж, дэлхийн дулаарлыг 2 хэмд барих, нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй эдийн засгийг санхүүжүүлэх зорилтуудад зээлийн багцаа уялдуулахыг зорьж байна.

тогтвортой
хөгжлийн
тайлан
2020

Эрхэм харилцагч, түншүүд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

Та бүгдийн хамтын ажиллагаа, дэмжлэгийн тусlamжтайгаар Голомт банкны анхны “Тогтвортой хөгжлийн тайлан”-г танилцуулж байгаадаа таатай байна. Энэ мөчийг тохиолдуулан та бүгдэд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

2020 онд дэлхий нийтээр Ковид-19 цар тахалт өвчинд нэрвэгдэж, гэнэтийн сорилт, бэрхшээлийг туулсан жил болж өнгөрлөө. Одоо ч энэ байдал дэлхийн өнцөг булан бүрт үргэлжилж, олон хүмүүс, бизнес эрхлэгчид хүнд нөхцөлд байсаар байна. Гэвч удахгүй илүү сайхан цаг ирнэ гэдэгт найдаж байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд

бид бизнес болон тогтвортой байдлын уялдаа холбоог илүү тодоор харж чадлаа. Компаниуд өөрсдийн хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг ойлгон удирдахад илүү анхаарч, байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлууд, уур амьсгалын эрсдэл, олон талт байдал, хүний эрх мөн аюулгүй байдал зэргийг хангасан стратеги боловсруулан үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 он бидэнд байгаль дэлхийтэйгээ тогтвортой харилцаа тогтоохын чухлыг санууллаа.

Голомт банк нь 2020 онд тогтвортой хөгжлийн хүрээнд олон чухал ажлыг хэрэгжүүлж, бизнесийн болон дотоод үйл ажиллагаагаа шинэчиллээ. Эдгээрээс онцлох үйл явдлуудыг дурдвал:

Тогтвортой хөгжлийн бодлого

Байгаль орчин, нийгмийн хүрээнд банкны баримтлах зарчмуудыг үйл ажиллагааныхаа бүх шатанд тодорхойлж, НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон улсын Үндэсний Зорилтот Хувь Нэмэртэй өөрийн бодлогыг уялдууллаа.

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг Олон Улсын Санхүүгийн Корпорациас тодорхойлсон эрсдэлийн төрлүүдтэй уялдуулж, зээлийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээчийн үнэлгээ хэрэгжиж эхэллээ.



Ажилтнуудад зориулсан Тогтвортой хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр

Ажилтнуудын нийт 80% нь тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ чиглэлээр сургалтад хамрагдлаа.

Банкны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн менежмент

Банканд хог хаягдлыг ангилах дотоод системийг нэвтрүүлж мөн эрчим хүч, усны хэрэглээг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Ногоон зээлийн хөгжүүлэлт, тайлагнал

Ногоон зээлийн багцыг нэмэгдүүлж, Монгол Улсын Ногоон Таксономийн дагуу Монголбанканд тайлагнаж эхэллээ.

2020 онд гаргасан бидний хичээл зүтгэлийн үр дүнд Голомт банк нь Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Монголбанк, Олон Улсын Санхүүгийн Корпорациас хэрэгжүүлсэн Тогтвортой Санхүүжилтийн үнэлгээгээр "A" үнэлгээ авч, өмнөх жилийн үнэлгээгээ ахиуллаа. Түүнчлэн Монголбанк 2020 оны "Онцлох Тогтвортой Санхүүгийн Банк"-аар Голомт банкийг шалгаруулж байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага болон ногоон санхүүжилтийн хүрээнд гаргасан сайжруулалтыг онццоллоо.

Голомт банк нь НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилгаас гаргасан "Хариуцлагатай Банкны Зарчмууд"-ыг үндэслэгч банк бөгөөд тус хөтөлбөрийн "Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг

хамтын амлалт"-ын гишүүн банк билээ. Бид бодлого болон бизнесийн үйл ажиллагааг нийгмийн хэрэгцээтэй уялдуулж, дэлхийн дулаарлыг 2 хэмд барих, нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй эдийн засгийг санхүүжүүлэх зорилтуудад зээлийн багцаа уялдуулахыг зорьж байна. Тиймээс цаашид бид хариуцлагатай банкийг төлөөлөн, амлалтуудаа хэрэгжүүлэхэд хүчин чармайлтаа дайчлан ажиллаж, улсын тогтвортой өсөлтийн төлөө харилцагч түншүүдтэйгээ хамтран ажиллах болно.

Хүндэтгэсэн,

A handwritten signature in black ink, appearing to read "N. Kato".

Гүйцэтгэх Захирал
Нориhiro Като



БИЗНЕС СТРАТЕГИ

Монголын банкны салбарын тэргүүлэх Голомт банк нь 1995 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн салбартаяа шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг анхлан нэвтрүүлэгч, санхүүгийн зах зээлийн манлайлагч нь болсон системийн хэмжээний ууган банк юм.

Бидний бизнес

Алсын хараа

Дэлхийн жишиг Монголын банк

Эрхэмсэг оршихуй

Хөгжлийн голомт

Стратеги

Харилцагч төвтэй байх

Үнэт зүйлс



Шударга, зарчимч бай.
/INTEGRITY/

Бид шударга, ёс зүйтэй үйл ажиллагааг хөхиүлэн дэмжин, ёс журмын үлгэр дуурайл үзүүлэгч байна.



Хариуцлагатай бай.
/ACCOUNTABILITY & RESPONSIBILITY/

Бид гаргасан шийдвэрийнхээ үр дагавыг бүрэн хариуцан, алдааг олж түүнээсээ байнга суралцана.



Хайрцагнаас гарч сэтгэ.
/INNOVATION/

Тархиа нээлттэй байлгаж, цаг ямагт дэлхийн хөгжилтэй эн зэрэгцэн, шилдэг туршлагаас тасралтгүй суралцана.



Чин хүсэл эрмэлзэлтэй бай.
/PASSION/

Бид хийж буй үйлдэл бүхнээ чин сэтгэлийн угаас үйлдэнэ.



Бууж өгөхгүй бай.
/CONSISTENCY/

Тууштай байснаар амжилт даган ирдэг. Бид оновчтой шийдвэр гарган, гаргасан шийдвэртээ үнэнч байна.



Хамтаж сэтгэлгээтэй бай.
/COLLABORATION/

Хувийн амжилтаас илүү багийн эрх ашгийг илүүдүүзэн амь нэгтгэй, хамтаж байна.



Хувь нэмрээ оруул.
/CONTRIBUTION/

Үргэлж өөрсдийгөө сэдэлжүүлж банкандaa болон эх орныхоо хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулна.



Харилцагч төвтэй бай.
/CUSTOMER ORIENTED/

Бид харилцагдаа ямагт эхэнд тавьж, энгийн ойлгомжтой байдлыг эрхэмлэн ажиллана.

Нийгэм дэх бидний оролцоо

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд томоохон үүрэг гүйцэтгэж буй Голомт банк нь 2020 онд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд дараах хувь нэмрийг оруулсан байна.

Эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр

- Шилдэг татвар төлөгч байгууллага: 119.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн
- Хамгийн олон ажлын байр бий болгосон байгууллага: 2334 хүнийг ажлын байраар хангасан
- Банкны нийт актив: 7.3 их наяд /Монгол Улсын банкны салбарын 20%-ийг бурдүүлсэн/
- Харилцагчийн эх үүсвэр: 5.3 их наяд төгрөг
- Гаргасан зээлийн хэмжээ: 3.2 их наяд төгрөг

Санхүүгийн тогтвортой байдалд оруулсан хувь нэмэр

- Монгол Улсын иргэн бүрийг хуримтлалтай болгох зорилго бүхий “Үндэсний хуримтлалын хөтөлбөр”-ийг санаачлан хэрэгжүүлснээр өдгөө 200,000 харилцагч энэхүү аянд нэгдэж, хуримтлалтай болоод байна.
- Харилцагчдадаа санхүүгийн сахилга бат олгох, богино хугацааны санхүүгийн хэрэгцээг нь хангах үүднээс “Зэс” дараа төлбөрт картыг зах зээлд гаргасан нь Монгол Улсын кредит картын зах зээлд тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Санхүүгийн дэд бүтцэд оруулсан хувь нэмэр

тогтвортой
хөгжлийн
тайлан
2020



Санхүүгийн хүртээмжтэй байдал



Тогтвортой хөгжлийн стратегийн чиглэл

Голомт банк 2019 оны 9 сарын 22-ны өдөр Нью-Йорк хотноо “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч банкнуудын нэг болж, өөрийн үйл ажиллагааг “Тогтвортой хөгжлийн зорилтууд” болон “Парисын гэрээний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтууд”-тай уялдуулахаа тунхагласан билээ.

Тогтвортой хөгжлийн зорилго



Голомт банк “Тогтвортой санхүүжилтийн бодлого”-ыг 2015 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байсан бөгөөд 2019 онд уг бодлогыг “Тогтвортой хөгжлийн бодлого” болгон өөрчилснөөр зөвхөн санхүүжилт бус банкны бүх шатны үйл ажиллагааг хамруулан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд бид өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан уур амьсгалын тэнцвэрт хүрэхэд шаардагдаж буй эдийн засгийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс гадна дотоод үйл ажиллагаагаа байгаль, нийгэмд ээлтэй болгохоор зорин ажиллаж байгаа бөгөөд бидний баримталж буй стратегийн үндсэн чиглэл нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад анхаарал хандуулах, тогтвортой, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох юм.

Голомт банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд баримталж буй стратеги



Тогтвортой
бизнесийн үйл
ажиллагааг явуулах



Нийгэм,
байгаль
орчны асуудлуудад
анхаарал тавих



Сэтгэл ханамжтай
ажлын байрыг
бий болгох



ТОГТВОРТОЙ БИЗНЕС

Банк санхүүгийн байгууллагын хувьд тогтвортой бизнесийн үйл ажиллагаа явуулах, тогтвортой санхүүжилт олгох нь байгаль орчин, нийгэмд зэрэг нөлөө үзүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх, мөн НҮБ-ын “Тогтвортой Хөгжлийн Зорилтууд”-ыг дэмжин ажиллахад хамгийн чухал салбар юм.

Тогтвортой санхүүжилт



Голомт банк нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс гадна гадаад, дотоодын нийт 40 гаруй төслийн зээлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх зэрэг үр ашгийг нэмэгдүүлэн ажилласаар байна.

Үүний хүрээнд 2020 онд нийт 57.5 тэрбум төгрөгийн тогтвортой санхүүжилтийн зээлийг 55 аж ахуйн нэгжид олгосон ба нийт 400 гаруй ажлын байрыг шинээр бий болгож, 706 ажлын байрыг хадгалсан байна. 2020 оны турш үргэлжилсэн Ковид-19 цар тахлын үед Голомт банк жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгч компаниуд болон хувиараа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин хөнгөлөлттэй төслийн зээл олгон дотоодын эдийн засгийг дэмжин ажиллалаа.

13

Тогтвортой санхүүжилтийн хүрээнд дараах байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллалаа. Үүнд:

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтран хэрэгжүүлсэн “Нийслэлийн хүн амын 2019-2020 оны өвөл, хаврын махны үнийг тогтвортжуулах, махны нөөц бүрдүүлэх хөтөлбөр”-т хамтран ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд 10.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт хийсэн. Уг харилцагч байгууллагууд нь тухайн санхүүжилтээр нийт 1,850 гаруй тонн мах нөөцлсөн ба зах зээлд махны хомсдол үүсэж эхэлдэг 3-6 саруудад зах зээлийн үнээс хямд ханшаар борлуулсан. Түүнчлэн 2020 оны 11 сарын 11-нд зарлагдсан бүх нийтийн бэлэн байдлын зэрэг тогтоосон хугацаанд мөн уг хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн нөөцийн махыг нийслэлийн хүн амын хэрэгцээнд хөнгөлөлттэй үнээр борлуулсан.

- “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах” 2 үе шаттай зээлийн төслийн хүрээнд бус нутгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарт 800 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн ба уг төслөөр дараах нийгмийн эерэг нөлөөг бий болгосон. Үүнд:
 - Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах;
 - Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах;
 - Эмчилгээ, үйлчилгээ нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;
 - Орон нутагт жишиг үйлчилгээ, эмчилгээ үзүүлэх зорилгоор Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн 5 давхар эмнэлгийн барилга ашиглалтад оруулах;
 - Ажлын байр нэмэгдүүлэх.
- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл”-ийн зээлийн хүрээнд газар тариалан эрхлэгч иргэдийг дэмжин нийслэлийн хүн амыг эрүүл ногоогоор хангах ажил хийгдсэн.
- Дотоодын эдийн засгийг дэмждэг “Алт” хөтөлбөр, “Газар Тариалан” хөтөлбөр болон экспортыг нэмэгдүүлдэг “Ноолуур” хөтөлбөрт амжилттай оролцож эдгээр салбарын харилцагч нартаа хөнгөлөлттэй зээл олгон дэмжиж ажиллалаа.



Ногоон зээл

2019 оны 12 сард Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Хадгаламжийн даатгалын корпорациас хамтарсан тушаал гаргаж “Монгол Улсын Ногоон Таксономи”-ийг баталсан. Ногоон Таксономи нь байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид Ногоон Таксономийг ашиглан ногоон зээл, төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох боломжтой болсон.

тогтвортой
хөгжлийн
ТАЙЛАН
2020

Ногоон Таксономи батлагдснаар Монгол Улсын арилжааны банкнууд 2019 оны 4-р улирлаас эхлэн өөрсдийн ногоон зээлийг ангилан, сайн дураар Монголбанканд тайлагнаж эхэлсэн билээ. Голомт банкны хувьд ч мөн улирал бүр Ногоон Таксономийн дагуу ногоон зээлийн багцаа тайлагнан, багцын хэмжээг жил бүр нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.


2020 оны Ногоон зээлийн багц (сая.төг)



2020 оны 3-р улирлын байдлаар Голомт банкны ногоон зээлийн багцын нийт дүн нь 192,685.9 сая төгрөг байсан нь нийт багцын 6.4%-ийг эзэлж байна. Өнгөрсөн 2018 оны 3-р улирлын байдлаархи ногоон зээлийн багц нь нийт зээлийн багцын 1.74%-ийг эзэлж байсан бол 2019, 2020 онуудад банк харилцагчдын ногоон төсөл хөтөлбөрийг дэмжин ажиллаж багцын хэмжээг 5%-аар нэмэгдүүлж чадлаа.

Ногоон зээлийн багц нь нийт 8 үндсэн ангилалд хуваагдаж байгаа бөгөөд эдгээр нь сэргээгдэх эрчим хүч, бага бохирдуулагч эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга, бохирдоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа, тогтвортой ус, хаягдлын хэрэглээ, тогтвортой ойн менежмент болон ойг хамгаалах, карбон бага тээвэр юм. Голомт банкны ногоон зээлийн багц нь дараах байдлаар задарч байна.

Ногоон зээлийн багц (хувиар)



Жендерийн тэгш байдал



Ажлын байран дээрх жендерийн тэгш байдлыг хангах

15

Голомт банк нь 2018 оноос эхлэн “Жендерийн тэгш байдлын хороо”-г бий болгож, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлснээр ажилтан бүр банкны үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох, байгууллагын үр ашиг болон хөгжлийн бодлогод тэнцүү ашиг хүртэх боломж улам нээлттэй болсон. Ингэснээр ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалтаас сэргийлж, мэдээллийн хүртээмж, хариуцлагын тогтолцоог тэгш эрхийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж, байгууллагын соёлыг эерэг, тэгш хандлагатайгаар төлөвшүүлэх, ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал ач холбогдлыг нэмэгдүүлээд байна.

2020 оны байдлаар Голомт банкны нийт ажилтны тоо 2334-д хүрсэн ба хүйсийн харьцаагаар нь авч үзвэл талаас дээш буюу 69 хувийг эмэгтэйчүүд, 31 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Харин удирдлагуудын 52 хувьд эрэгтэйчүүд, 48 хувьд эмэгтэй удирдлагууд ажиллаж байгаа нь хүйсийн харьцааны хувьд удирдах, шийдвэр гаргах түвшинд эн тэнцүү хөдөлмөр эрхэлж байгааг харж болохоор байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих

Голомт банк нь жендерийн эрх тэгш байдлыг дотооддоо ханган ажиллахаас гадна харилцагчдынхаа жендер, түүнийг дагасан эдийн засгийн хөгжлийн асуудлыг анхааран ажилласаар ирсэн. Манай улсын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 60-аас дээш хувийг хүн амын дийлэнх хэсгийг бүрдүүлэгч эмэгтэйчүүд эзлэн баялаг бүтээж, ажилгүйдлийг бууруулан, эдийн засгийн түлхэх хүч болон нийгэмд эзлэх байр сууриа бэхжүүлсээр байна.

Голомт банкны нийт харилцагчдын 70 хувийг эмэгтэй харилцагчид эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн санхүүгийн боловсролын түвшин нэмэгдэж, банкны төлбөр тооцоо болон зээлийн үйл ажиллагаанд оруулах хувь нэмэр жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Нийт зээлтэй харилцагчдын 50-аас илүү хувийг мөн эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд Голомт банкнаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжин санхүүгийн чадавхийг нь сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээгээ идэвхтэй эрхлэх боломжоор хангахад анхаарал хандуулан ажиллаж байна.

2020 онд жижиг, дунд бизнес эрхлэгч 200 гаруй эмэгтэйчүүдэд зориулан санхүүгийн боловсрол олгох, төслийн удирдлага, бизнесийн өргөжилт, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд тулгарч буй асуудлуудыг тодорхойлон техникийн болон санхүүгийн зөвлөгөө өгөх сургалт, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллалаа.



Голомт банкны зүгээс эмэгтэйчүүдэд санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, ахисан түвшинд хүргэж, эмэгтэйчүүдэд өөрийн хийж чадах зүйлсээ бизнес болгон ашиг орлоготой болох, одоогийн бизнесээ өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай мэргэжлийн сургалт, мэдлэг болон санхүүгийн дэмжлэг туслалцааг хүргэх зорилго бүхий “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хороо”-г 2020 онд байгууллаа. Уг хороо нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олон улсын

байгууллагуудтай харилцаа холбоо тогтооход нь дэмжин ажиллах, нийгмийн сайн сайхны төлөө чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлэхэд мөн чиглэх юм.

Хороог байгуулснаар бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжин дараах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан төлбөр тооцооны үйлчилгээ болон бизнесийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн тэлэх, цар тахлын үед санхүүгийн хүндрэлээс даван гарахад нь туслах зорилготой зээлийн тусгай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх;
- Гарааны бизнес болон одоо эрхэлж буй бизнесийн цар хүрээг тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн болон бизнесийн зөвлөх үйлчилгээ бүхий сургалт хөгжлийн академи бий болгох;
- Эмэгтэйчүүд рүү чиглэсэн олон улсын болон төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Технологид суурилсан шинэ бизнесийн орчин, дижитал шилжилтийн үед эмэгтэй бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг тодорхойлон мэргэжлийн зөвлөгөө өгч, дижитал шилжилтийг хамтдаа хийх боломжийг олгох зэрэг үйл ажиллагаанууд багтаж байна.

Хамтын ажиллагаа



Тогтвортой хөгжил болон ногоон санхүүжилтийн хүрээнд Голомт банк нь хамтын ажиллагааг чухалчлан үзэж дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж сайн туршлагуудаас суралцан банкны үйл ажиллагаанд нэвтрүүлж байна.

Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ToC Холбоо)



Голомт Банк нь ToC Холбоо үүсгэн байгуулагдсан цагаас хойш үндсэн гишүүн нь байж Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн 8 зарчмыг дэмжин сайн дураар хэрэгжүүлэн ажилладаг билээ. Түүнчлэн ToC

Холбооны Төлөөлөн Удирдагчдын Зөвлөлд Голомт Банкны удирдлагаас сонгогдон Холбооны үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахад хувь нэмэр оруулан ажиллаж байна. Голомт банк нь ToC Холбооноос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, сургалтуудад идэвхтэй оролцон тогтвортой санхүүжилтийн чадавх бүрдүүлэн өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж байна.

17

ToC-ийн 8 зарчим

Байгаль орчноо хамгаалах	Хүний эрх, нийгмийг хамгаалах	Соёлын өвийг хамгаалах	“Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих	Санхүүгийн хүртээмжийг дэмжих
Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих	Ил тод байдал, хариуцлагыг дэмжих	Манлайлан үлгэрлэх		

НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилга (UNEP FI)



2019 оны 9 сард Голомт банк нь НҮБ-ын “Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилга”-аас гаргасан “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-д албан ёсоор нэгдэн НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон

Парисын хэлэлцээрийн зорилтуудтай өөрийн үйл ажиллагааг уялдуулан, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулан ажиллахаа албан ёсоор баталсан билээ. Голомт банк нь анх 2017 онд UNEP FI-ийн банкны хороонд нэгдэж “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-ыг боловсруулах ажлын багт оролцон эдгээр зарчмуудыг үндэслэгч анхны 30 банкны нэг болсон юм. Одоогоор Зарчмуудад дэлхийн нийт 197 банк нэгдсэн байгаа бөгөөд эдгээр 6 зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх, тайлгахаа зэрэг төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллаж байна. Голомт банкны хувьд 2020 онд “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт” ажлын хэсэгт нэгдэн банкны зээлийн багцын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тооцоолох болон бууруулах зорилтыг хэрхэн тавих тухай судлан ажиллалаа. 2021 оноос эхлэн Зарчмуудад нэгдсэн банкнууд өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөний дагуу зарчмуудыг хэрэгжүүлэн тайлagnаж эхлэх юм.

ХАРИУЦЛАГАТАЙ БАНКНЫ
ҮНДСЭН 6 ЗАРЧИМ

Inspired by Green

НИЙЦЭЛ

НӨЛӨӨЛӨЛ &
ЗОРИЛТОТ ТҮВШИН

ХАРИЛЦАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД

ХАМТРАН
АЖИЛЛАГЧИД,
ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИД,
АЖИЛТНУУД

ЗАСАГЛАЛ
& СОЁЛ

ИЛ ТОД
БАЙДАЛ
& ХАРИУЦЛАГА

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт (Collective Commitment to Climate Action)

НҮБ-ын “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-д нэгдсэн банкнууд дундаас сайн дурын 38 банк хамтран “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт”-ыг мөн адил 2019 оны 9 сард байгуулсан юм. Голомт банк нь эдгээр 38 банкны нэг бөгөөд дэлхийн дулаарлыг 2 хэмд барих, net zero economy буюу цэвэр эдийн засагт шилжихэд банкны салбарыг төлөөлөн хувь нэмэр оруулах зэрэг амлалтыг хэрэгжүүлэхээр уг санаачилгад нэгдсэн билээ. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалтад нэгдсэн банкнуудын эхний 1 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын тайланг НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилгаас 2020 оны 12 сарын 8-нд олон нийтэд танилцуулсан бөгөөд Голомт банкны зээлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын шинэчилсэн системийг энэхүү тайландаа онцолж оруулсан юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт

“Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт”-д нэгдсэн дэлхийн 38 банкны эхний 1 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргэхэд таатай байна.



ТА QR КОД УНШУУЛАН тайлантай танилцана уу.





Харилцагчийн санхүүгийн аюулгүй байдал

Банк санхүүгийн байгууллагын хувьд олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг мөрдөн бизнесийн харилцаандаа өндөр ёс зүйтэй байх, харилцагч нарынхаа санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, залилангаас урьдчилан сэргийлэх нь үйл ажиллагаа урт хугацаанд, тогтвортой явах томоохон хүчин зүйл билээ. Тэр ч утгаараа Голомт банк Комплаенсийн бодлого, Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг цогцоор нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

Комплаенсийн бодлого

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ёс зүйн хэм хэмжээг заасан “Байгууллагын засаглалын кодекс”-ыг баталсантай ажилтан бүр танилцан, өдөр тутмын ажилдаа чанд хэрэгжүүлэн ажилладаг билээ. Түүнчлэн, Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо сар бүр хуралдаж Комплаенсийн болон бусад эрсдэлийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

Комплаенсийн үйл ажиллагаагаа дэмжиж, хөрөнгө оруулалт хийх, хариуцсан ажилтнуудыг олон улсын сургалтад хамруулж мэргэшүүлэх зэрэгт Голомт банкны зүгээс ихээхэн ач холбогдол өгөн ажилладгийн нэг жишээ нь гүйлгээний хяналтын автоматжуулсан системийг нэвтрүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн Комплаенсийн мэргэжилтнүүдийг бэлтгэж буй явдал юм. Үүнээс гадна бид банкны комплаенсийн соёлыг бэхжүүлэх, ажилтан бүртэй холбоотой ажиллах, тэдний үүрэг оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Комплаенсийн төлөөлөгч” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд төлөөлөгчдийг нэгж бүрээс томilon комплаенсийн үйл ажиллагааг богино хугацаанд, үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна.

Комплаенсийн хөтөлбөрийн бас нэгэн чухал хэсэг нь сургалт хөгжлийн үйл ажиллагаа бөгөөд ажилтан бүр Комплаенсийн сургалтуудад хамрагдаж, жилд 2 удаа бичгээр шалгалт өгч, мэдлэгээ бататгаж байна. Шалгалтын үнэлгээ нь нэгжийн KPI буюу гүйцэтгэлийн үнэлгээнд нөлөөлгөөрөө онцлогтой юм. Мөн үндсэн бизнес болон харилцагчидтай нүүр тулж ажилладаг ажилтнууд Комплаенс болон ёс зүйн дүрмийн гүнзгийрүүлсэн сургалтуудад хамрагдах тухай бодлого боловсруулан ажиллаж байна.

Комплаенсийн хэлтсийн чиг үүрэг нь Комплаенсийн бодлогын хэрэгжилтээс гадна Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам, Ёс зүйн дүрэм, Авлигын эсрэг бодлого, Ашиг сонирхлын зөрчил, Шүгэл үлээх/зөрчил мэдээлэх зэрэг ёс зүйн хэм хэмжээг заасан бусад дүрэм журмын хэрэгжилт зэрэг өргөн цар хүрээг хамардгаараа онцлогтой.

Бидний зүгээс олон улсын болон дотоодын Комплаенсийн стандартуудыг Голомт банк хэрхэн дагаж мөрдөж буй талаарх мэдээлэл, холбогдох баталгаажуулалтуудыг банкны вэбсайт дээр нээлттэй байршуулан харилцагч, хамтран ажилладаг түншүүддээ тогтмол мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

Дэлхий дахинаа Дижитал шилжилт, Үүлэн технологийн хувьсал, Кибер аюул занал, Хувийн өгөгдлийн аюулгүй байдал зэрэг технологийн өөрчлөлтүүд нь хамгийн ихээр бизнесийн байгууллагууд болон улс орны хөгжилд нөлөөлж эхлээд байна. 2020 оны Дэлхийн эдийн засгийн форум дээр улс орон, бизнесийн байгууллагуудад хамгийн их эрсдэл дагуулах топ эрсдэлүүдийг тодорхойлоход кибер аюул занал нь 3 дугаарт эрэмбэлэгдэж байна гэж дүгнэсэн. Мөн кибер гэмт хөргээс улбаатай 2 их наяд долларын хохирол учирсан нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувь юм. 2021 он гэхэд энэ хэмжээ 6 их наяд долларт хүрнэ гэсэн таамаглалууд гарч байна. Иймд байгууллага бүр мэдээллийн аюулгүй байдлын цогц шийдэл, хамгаалалтыг хэрэгжүүлэх, Мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг түгээх нь чухал юм.

Олон улсын стандартууд



Голомт банк нь Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартууд болох ISO27001, PCI-DSS стандартуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлын стандарт болох ISO27001-ийг хэрэгжүүлсэн нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадсан. Мөн PCI-DSS буюу Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлснээр картын аюулгүй байдлыг бүх түвшинд хамгаалах, хяналтыг нэмэгдүүлэх, цаашлаад картын луйврын гүйлгээг багасгах ач холбогдолтой. ISO27001 болон PCI-DSS стандартуудын баталгаажуулах аудитууд жил бүр амжилттай хийгдэж байна.

“Ятгах тусам нягтал” аян

Харилцагч болон иргэдэд санхүүгийн боловсрол олгох, өнөө үед ихээр нэмэгдэж буй цахим орчин дахь залилах гэмт хөргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанк, Цагдаагийн ерөнхий газартай хамтран “Ятгах тусам нягтал-2” аяныг хэрэгжүүлсэн билээ. Аяны хүрээнд банкны бутээгдэхүүн, үйлчилгээг аюулгүй хэрэглэх, цахим халдлагаас сэргийлэх уриалгуудыг гарган ажилласан юм.

21



“Харуул занги” аюулгүй байдлын тэмцээн



Олон нийтэд мэдээллийн аюулгүй байдлын үнэн зөв бодитой ойлголт, мэдлэгийг түгээх, мэдээллийн аюулгүй байдлын салбарт шинэ санаа, авьяас чадварыг илрүүлэх, чадварлаг мэргэжилтнийг бэлтгэх зорилгоор “Харуул занги” тэмцээнийг Голомт банк жил бүр зохион байгуулан ажиллаж байна. Уг тэмцээнийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд мөн “ХАРУУЛ ЗАНГИ U18” нэртэйгээр тогтмол явуулж байна.

Харилцагч байгууллагад зориулсан Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ

Өнөөгийн дижитал шилжилтэд мэдээлэл гэдэг нь байгууллагын хамгийн үнэ цэнтэй хөрөнгө юм. Бизнесийн байгууллага нь зорилгодоо хүрэхэд мэдээллийн бүрэн бүтэн, хүртээмжтэй мөн нууцлагдсан байдал нь чухал үүрэгтэй. Сүүлийн жилүүдэд харилцаа холбооны салбарт гарсан шинэчлэлүүд нь олон тооны байгууллагуудыг бүтцийн өөрчлөлт хийхэд хүргэн мэдээллийн технологийн хөгжлийг түргэсгэж, хэрэглээг нь ч нэмэгдүүлж байна. Тиймээс харилцаа холбооны дэд бүтцээ хамгаалахын тулд тохирох Мэдээллийн аюулгүй байдлын арга хэмжээг авах нь ихээхэн чухал болоод байна. Энэ процессыг хэрэгжүүлэхэд нэн чухал хэсэг нь Итгэмжлэгдсэн (trusted) Мэдээллийн Аюулгүй байдлын мэргэжлийн үйлчилгээг авах юм. Голомт банк нь харилцагч байгууллагын Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад дараах цогц үйлчилгээг хүргэж байна.

- **Solution provider service:** Харилцагч байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, одоогийн нөхцөл байдлыг үнэлэн Мэдээллийн аюулгүй байдлын боловсон хүчин, процесс, технологийн талын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шийдэл санал болгох.
- **Education service:** Байгууллагын ажилтнуудад зориулсан анхан, дунд болон гүнзгий түвшний Мэдээллийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр зохион байгуулах, ажилтны мэдлэгийн түвшинг үнэлэх, туршин шалгах.
- **Penetration testing service:** Байгууллагын мэдээллийн систем, програм хангамж, сүлжээний эмзэг байдлыг илрүүлэх, нэвтрэх шалгалтыг зохион байгуулах замаар технологийн эрсдэлийг бууруулах.
- **Incident response service:** Байгууллага дээр бий болсон кибер будлианд шуурхай хариу арга хэмжээ, халдлагын дараах ул мөрийн шинжилгээ, дүгнэлт гаргах.

Хамтын ажиллагаа

Мэдээлэл технологийн шинэ боловсон хүчинийг дэмжих зорилгоор Шинжлэх Ухаан



Технологийн Их сургуулийн Мэдээлэл Холбооны Технологийн сургуультай жил бүр хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд Голомт банк нь мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч оюутнуудад бодит тоног төхөөрөмж дээр дадлагажих дэмжлэг үзүүлж байгаагаас гадна жил бүр зохион байгуулгадаг мэргэжил сурталчлах өдөрлөгт ажлын байр санал болгох, илтгэл тавих, хамтын ажиллагааг дүгнэх зэргээр оролцож байна. Түүнчлэн Голомт банк нь MXTC-ийн мэдээллийн технологийн чиглэлийн хөтөлбөрүүдээр суралцаж байгаа оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийх орчноор ханган өндөр мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил бүхий чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж байна.



НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИН

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг үйл ажиллагаандаа тусган, “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг хэрэгжүүлэгч Голомт банк нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа санал болгож, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байна.

Байгальд ээлтэй бизнес



Голомт банк харилцагчдынхаа зан төлөв, хэрэгцээнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгоходоо байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ болох Дижитал банкны үйлчилгээг нэвтрүүлэн цаасны хэрэглээг бууруулан ажиллаж байна.

Цаасгүй банкны үйлчилгээ

Дижитал банк 5.0 үйлчилгээ

Шинэчлэлийн хүрээнд банкны дижитал сувгууд болох Интернэт банк, Смарт банк үйлчилгээний шинэ хувилбарыг харилцагчдадаа хүргээд байна. Ингэснээр харилцагчийн цаг завыг хэмнээд зогсохгүй, банкны гүйлгээний цаасыг хэмнэж байна.

25

Дижитал хэтэвч SocialPay аппликэйшн

Худалдан авалт хийхдээ дижитал хэтэвчээрээ QR код ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой. Ингэснээр харилцагч биедээ карт авч явах шаардлагагүйгээр гар утсаараа төлбөр тооцоо хийх боломжийг олгож байна.

SocialPay Виртуал карт

Монголын анхны олон улсын эрхтэй Виртуал картыг SocialPay аппликэйшнд амжилттай нэвтрүүлснээр харилцагч заавал банкан дээр дараалалд зогсолгүй, дурын төлбөр тооцоогоо виртуал байдлаар хийх боломжийг олгож байна. Одоогийн байдлаар 200,000 гаруй виртуал карт ашиглаж байгаа нь уг хэмжээний картын хэвлэлийн зардал, хог хаягдлыг багасгаж байна гэсэн үг юм.

Дэлгүүр хэсэхдээ Дижитал хэтэвчтэйгээ

Дэлгүүр болон бусад бүх төрлийн үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхдээ ухаалаг гар утастайгаа байхад л хэтэвч авч явах шаардлагагүй болж, SocialPay-ээр худалдан авалт хийх боломжийг анхлан нэвтрүүллээ.

Зээлийн бодлого

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Голомт банк нь зээл, төслийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийг харгалzan үзэх ба уг эрсдэлийг удирдах боломжтой гэж үзсэн тохиолдолд зээл олгох, төслийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Зээлийн үйл ажиллагаанд 2019 оны 9 сараас эхлэн мэргэшсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээчинтэй болсон бөгөөд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг IFC, Монголбанк болон тогтвортой хөгжлийн зарчмуудыг тусган шинэчилсэн.

Үүнд:

- Байгаль орчноо хамгаалах
- Хүний эрх, нийгмийг хамгаалах
- Соёлын өвийг хамгаалах
- Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих
- Манлайлан үлгэрлэх

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ бүхий мэдээллийн баазыг бүрдүүлэх, улмаар эрсдэлийг мэдээлэх, тайлагнах, хянах боломжийг бүрдүүлэх зорилгоор үнэлгээг системд нэвтрүүлсэн.

2020 оны 1 сараас хойш банкны хэмжээнд байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй байж болзошгүй эдийн засгийн секторуудын хувьд 100 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш урт хугацаатай бүх бизнесийн зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж байна.

Зээлийн бодлогоор хориглох үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд санхүүжилт хийхгүй, анхаарах үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд эрсдэлийн үнэлгээ хийн зээл олгож байна.

Банкны хувьд зээлийн бодлогын дагуу байгаль орчин, нийгэмд өндөр хор хөнөөлтэй дараах төрлийн бизнес, үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй. Үүнд:

- Мөрийтэй тоглоом
- Хүний наймаа, садар самуун сурталчлах, хүүхдийн хөдөлмөр
- Зэвсгийн худалдаа, үйлдвэрлэл
- Олон шатлалт маркетинг буюу сүлжээний бизнес
- Мансууруулах ургамал тариалал, үйлдвэрлэлт, тээвэрлэлт
- Зөвшөөрөлгүй эм, хорт бодисын худалдаа
- Ховордсон ан амьтны агнуур, агнуурын тэвчишгүй хэлбэр, худалдаа
- Аюултай хог хаягдлын тээвэрлэлт, устгал
- Ач холбогдолтой бүсэд мод бэлтгэл
- Цахим тоглоомын үйл ажиллагаа

Мөн анхаарах шаардлагатай байгаль орчин, нийгэмд нөлөө үзүүлдэг бизнесүүдийн хувьд эрсдэлийн үнэлгээ хийн, санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэж байна.

Боловсролд чиглэсэн үйл ажиллагаа



Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Монгол Улсад бизнесийн байгууллагуудаас анхлан нийгмийн хариуцлагын хүрээнд санаачилсан тус хөтөлбөрийн хүрээнд Голомт банкны зүгээс өнөөг хүртэл нийт 1400 оюутанд нэг тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг олгон, сурах хүсэл эрмэлзэлд нь хөрөнгө оруулжээ. Голомт банкны оюутны тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан оюутан нь бүтэн жилийн турш тэтгэлэг авахаас гадна Голомт банкны судлаач оюутны багт ажиллах, G-Student club-ийн гишүүн болж өөрийгөө хөгжүүлэх цаашлаад сургуулиа төгсөөд банканд ажиллах боломжтой болдгоороо томоохон ач холбогдолтой юм.

2020 оны тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалтад нийт 30 орчим магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 700 гаруй оюутан өрсөлдөж, Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн 20 их, дээд сургуулийн 23 мэргэжлийн нийт шилдэг 100 оюутан шалгарлаа.



“Судлаач оюутан” хөтөлбөр

27

Голомт банк 2005 оноос эхлэн оюутан залуусын онолын мэдлэгийг практик дээр хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагаатай холбоотой судалгааны ажилд оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Судлаач оюутан” хөтөлбөрийг 15 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад бизнесийн бодит төслүүд дээр ажиллаж өөрийгөө сорих, банкны мэргэшсэн мэргэжилтнүүдийг дагалдаж суралцах, тэдэнтэй хамтран ажиллах болон өөрийгөө хөгжүүлэх цогц сургалтуудад хамрагдаж цалинтай ажиллах боломжуудыг олгодгоороо онцлог юм. 2020 онд тус хөтөлбөр хавар болон намар 2 удаа зохион байгуулагдсан бөгөөд нийт 5 сургуулийн 11 мэргэжлийн 41 оюутан амжилттай хамрагдлаа.

Internship opportunity 2K20


Их, дээд сургуулиудын оюутан залууст чиглэсэн дижитал мэргэжилтэн бэлтгэх “Internship Opportunity” хөтөлбөрийг Голомт банк 5 дахь жилдээ зохион байгуулсан ба уг хөтөлбөрт банканд ашиглагддаг бодит системүүд дээр дадлага хийх, туршилт явуулах, хувь хүний

хөгжлийн сургалтуудад хамрагдах, багийн болон хамтын ажиллагаанд чадавхжих, мэргэшсэн мэргэжилтнүүдийг дагалдаж суралцах ур чадваруудаа сайжруулах зэрэг давуу талтай. Мөн хөтөлбөрт хамрагдан дадлага хийснээр Голомт банкнаас сар бүр цалин олгохоос гадна бүтэн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдах гэх мэт маш олон боломжийг олгодгоороо оюутан залууст зориулж буй томоохон хөрөнгө оруулалт болдог юм.

Hackateen-2020 дэмжигч

Мэдээллийн технологийн гүнзгийрүүлсэн сургалттай, Ерөнхий боловсролын “Нэст Эдүкэйшн” сургуулиас орон даяар зохион байгуулж буй “Hackateen-2020” програмчлалын улсын олимпиадыг Голомт банк дэмжин ажиллаж, финалын шатанд шалгарсан сурагчдыг хүлээн авч, “Дэлхийн санхүүгийн түүхийн музей”-тэй танилцуулж, санхүүгийн салбар дахь мэдээллийн технологийн нөлөө, технологийн хөгжлийн чиг хандлага зэрэг олон чухал сэдвээр сургалт, илтгэлийг зохион байгуулан ажилласан билээ.


Санхүүгийн цогц боловсрол олгох Монголын анхны санхүүгийн хөтөч /finedu.mn/



тогтвортой
хөгжлийн
тайлан
2020

Голомт банк иргэд, харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор банк санхүү, эдийн засгийн ойлголтыг хамгийн энгийн, бодит амьдралд нийцүүлэн тайлбарласан Монголын анхны санхүүгийн хөтөч Finedu сайтыг зах зээлд танилцуулаад байгаа билээ. Finedu бол иргэд, бизнес эрхлагч, оюутан сурагч гээд хэн бүхэнд банк санхүү, эдийн засгийн анхан шатны цогц ойлголтыг багтаасан мэдлэг, мэдээллийн сан юм.

**Судалгаанд суурилсан оновчтой шийдвэр гаргалтад туслах DUA
судалгааны платформ /dua.golomtbank.com/**



Голомт банк сүүлийн 3 жилийн хугацаанд байгууллагын харилцагчдадаа зөвлөх үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд уг үйлчилгээгээ илүү өргөн цар хүрээнд хүргэхээр Монголдоо анхдагч эдийн засгийн судалгааны DUA /dua.golomtbank.com/ платформыг бүтээлээ.

DUA нь санхүүгийн менежер, эдийн засагч, бизнес эрхлэгч, судлаач хэн бүхэнд зориулсан вэб суурьтай судалгааны платформ юм. Энэхүү платформ нь гадаад, дотоод орчныг мэдэрч, нөхцөл байдлыг 360 градусаар харах боломжийг олгож, оновчтой шийдвэр гаргалтад туслах мэдээний анализ, нийтлэл, санхүүгийн зөвлөмж, подкаст зэрэг олон сувгаар хүргэх юм.



Эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа

Зүрх мартахгүй төсөл



Голомт банкны Алтантулхүүр хүүхдийн сан нь “Улаанбаатар Сонгдо” эмнэлгийн “Зүрх мартахгүй” төслийн албан ёсны хамтрагчаар ажиллах санамж бичгийг байгуулан ажиллаж байна. Уг төсөл нь зүрхний төрөлхийн гажигтай хүүхдүүдийг эх орондоо үнэ төлбөргүй эмчлүүлэх боломжоор хангаж байгаа бөгөөд Алтантулхүүр сан хүүхдүүдийн эмчилгээний зардлыг даахаас гадна Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй төрийн болон хувийн бүхий л аж ахуйн нэгж, байгууллагуудад хандан “Зүрх мартахгүй” төсөлд нэгдэж, бяцхан зүрхнүүдэд амьдрал бэлэглэхийг уриалан ажиллаж байна.



тогтвортой
хөгжлийн
тайлан
2020

Цус хандивлах аян

Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд Дэлхийн цусны донорын өдрийг угтаж “Цус сэлбэлт судлалын үндэсний төв”-тэй хамтран Цусны донорын өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. 2020 онд тус өдөрлөгт нийт 50 гаруй ажилтнууд хамрагдсан байна.

Covid-19 цар тахлын үеийн хандив

Дэлхий дахинаа шинэ коронавирусийн (Covid-19) тархалт өргөн хүрээнд дэгдэж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, ЭМЯ, Улсын онцгой комиссоос цаг алдалгүй арга хэмжээ авч, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаа билээ. Халдварт өвчний эрсдэлээс улс даяар өрнөж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа энэ үед Монгол Улсын хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө тэргүүн

эгнээнд зогсон, тархалт нь нэмэгдэж байгаа аюулт өвчний эсрэг цуцалтгүй тэмцэж буй ХӨСҮТ-ийн нийт эмч, сувилагч, албан хаагч нарт Голомт банкны хамт олны зүгээс талархал илэрхийлж, 100 сая төгрөгийн мөнгөн хандив өргөлөө.



Соёлын өвийг хамгаалахуй



“Дуурь бүжгийн эрдмийн театр”-ын дэмжигч

Монголын сонгодог урлагийг түгээх, сурталчлах зорилгоор Дуурь бүжгийн эрдмийн театрт жил бүр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

“Морин хуурын чуулга”-ын албан ёсны түнш

Үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор Голомт банк нь Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, Ерөнхий ивээн тэтгэгчээр 8 дахь жилдээ ажиллаж байна.

31





ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР

Голомт банк харилцагч нараа төдийгүй нийт ажилтнуудынхаа ур чадварыг сайжруулах, байгууллагын соёлоо бэхжүүлэх, ажилтнуудынхаа нийгмийн асуудал, эрүүл мэнд, идэвх оролцоог нэмэгдүүлэх, сурч хөгжих боломжоор хангах чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг билээ.



Сэтгэл ханамжтай ажлын байр



Ажилтнуудын эрүүл мэндийн хөтөлбөр

Голомт банк Анагаах ухааны магистр зэрэгтэй их эмчийн зөвлөгөөн дор ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, хянах, заавар зөвлөгөө өгөх, үзлэг шинжилгээ хийх ажлуудыг зохион байгуулж байна.

2020 онд авч хэрэгжүүлсэн эрүүл мэндийн хөтөлбөрийн үр дүн



33

Ажилтны хөнгөлөлт хангамжийн багц

Ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор спорт чөлөөт цаг, эмнэлгийн үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, сургалтын чиглэлийн нийт 25 байгууллагатай Голомт банкны ажилтан хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Ахмадын баяр

Голомт банканд тогтвортой суурьшилттай, өндөр бүтээмжтэй ажиллаж байгаад өндөр насны амралтаа авсан нийт ахмад ажилтнууддаа зориулан жилд 2 удаа буюу Цагаан сар, Ахмадын баяараар хүлээн авалт зохион байгуулдаг.

Спорт арга хэмжээ

Голомт банкны дэргэдэх Спорт хамтлаг нь жилд дунджаар 15 орчим тэмцээн, уралдаан, спортын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, дэмжиж ажилладаг. Голомт банк нь жил бүр уламжлал болгон бүх ажилтныг хамарсан цасны баяр, адал явдалт спорт явган аяллыг 23 дахь жилдээ амжилттай зохион байгуулаад байна.

“Талархлын захидал” аян

Тус үйл ажиллагааг 2019 оноос эхлэн 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа ба ажилтнууд талархаж явдаг удирдлага болон хамт олондоо захидал бичсэнээр байгууллагын дотоод уур амьсгал сайжирч, сэтгэл ханамжтай, бүтээмжтэй ажиллахад нь ээрэгээр нөлөөлдөг. Зул сарын баярыг угтаж тус хөтөлбөр хэрэгждэг ба 2020 оны хувьд нийт 200 ажилтан хамрагдсан байна.

“Үйдах завгүй хөгжицгөө” хөтөлбөр

Дэлхий нийтийн өмнө тулгамдаад байгаа цар тахлын үед ч ажилтнуудынхаа чөлөөт цаг, сурч хөгжихөд нь анхааран “Үйдах завгүй хөгжицгөө” хөтөлбөрийг энэ онд шинээр хэрэгжүүллээ. Тус хөтөлбөрийн хүрээнд өдөр бүр гадаад хэлээр цээжлэх өгүүлбэрүүд, шилдэг ном болон киноны хэлэлцүүлэг, танин мэдэхүйн уралдаан, хөгжөөнт тэмцээн, удирдах ажилтнуудын туршлагаа хуваалцах видео контентуудыг бэлтгэн ажилтнууддаа хүргэсэн.

Goodvibes 2.0

2018 оноос эхлэн 3 жилийн хугацаанд жил бүр GOODVIBES хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба тус хөтөлбөр нь ажилтнуудын 12-16 насны хүүхдүүдийн зуны амралтыг үр дүнтэй өнгөрүүлэхэд нь чиглэсэн сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг билээ. 2020 онд 20 хүүхэд хамрагдаж 2 сарын хугацаанд сонирхолтой сургалт, арга хэмжээнүүдэд оролцлоо. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах сэдэв агуулгаар сургалтуудыг зохион байгуулсан.

- Өсвөр насны хүүхдэд зориулсан биеэ зөв, эрүүл авч явах эрүүл ахуйн сургалт
- Гоо зүйн сургалт
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт
- Багаар хамтран ажиллах ур чадварын сургалт
- Дижитал орчинд өөрийгөө хөгжүүлэх боломжуудын тухай сургалт

Сурагчийн дадлага

2019 оноос эхлэн 2 жилийн хугацаанд жил бүр “Сурагчийн дадлага” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба тус хөтөлбөр нь ажилтнуудын 13-16 насны хүүхдүүд аав ээжийнхээ ажлын байртай танилцах, мэргэжлийн чиг баримжaa олж авах давуу талтай хөтөлбөр юм. 2020 онд нийт 5 нэгж дээр 6 ажилтны хүүхэд дадлага хийллээ.

Сургалт хөгжил



Сургалтын цаг
124,796



Оролцогчдын тоо
28,904



Нэг ажилтанд ногдох сургалтын цаг
65.6

Тэтгэврийн Ууган Сан



“Тэтгэврийн Ууган Сан” нь 2010 оны 7 сарын 2-ны өдөр ажил олгогч, ажилтнуудын санаачилгаар Монгол Улсын тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийж, хувийн тэтгэврийн системийг бий болгох замаар ажилтнуудыг тэтгэврийн насанд хүрэхэд нэмэлт тэтгэврийн хангалттай орлоготой байх нөхцөлийг бий болгох үндсэн зорилготойгоор анхлан байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тэтгэврийн Ууган Сан үүсгэн байгуулагдсан цагаас давхардсан тоогоор Голомт банкны 3,080 ажилтан банкныхаяа дэмжлэгтэйгээр тэтгэврийн хуримтлал буюу тэтгэврийн нэрийн данстай болсон байна. 2020 оны байдлаар Тэтгэврийн Ууган Санд нийт 1,300 ажилтан тэтгэврийн нэрийн данстай, нийт хуримтлалын хэмжээ 5.2 тэрбум төгрөг болсон. Мөн 2020 онд Голомт банкны зүгээс ажилтнуудынхаа тэтгэврийн хуримтлалд зориулж 350 сая төгрөг өгсөн байна.

Шагнал урамшуулал

Банкны 2400 гаруй ажилтнаас ажил үүргээрээ бусдыгаа манлайлсан шилдгийн шилдэг ажилтнуудаа шагнаж урамшуулахаас гадна 2020 оноос эхлэн “Бахархалт ажилтан” амжилт сайшаах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 160 гаруй ажилтан бахархалт ажилтнаар өргөмжлөгджээ.

“Knowledge sharing” эвент

Энэ нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээ болон чадамжийн үнэлгээгээрээ тэргүүлсэн ажилтнууд өөрсдийнхөө туршлагыг бусадтайгаа хуваалцдаг хөтөлбөр бөгөөд 2020 оны хувьд нийт 7 ажилтны 560 цагийн мэдлэг хуваалцах сургалтыг амжилттай зохион байгууллаа.

35

Уян хатан ажлын цаг

Ажилтан өөрийн ажлын ачаалал болон төлөвлөгөөтэй уялдуулан ажлын цагийн төлөвлөгөөгөө зохиож ажиллах боломж бүхий “Уян хатан ажлын цаг”-ийг хэрэгжүүлж эхэллээ. Энэ нь ажилтан өөрөө ажилдаа ирэх цагаа сонгох боломжтойгоос гадна долоо хоногийн 30 хувьд зайнлас ажиллах боломжтой юм. Мөн бие давхар ажилтан өдөрт 2 цаг, эрүүл мэндийн байдлаас хамааран 1-2 цагийн цалинтай чөлөө авах боломжтой юм.

Сургалт арга хэмжээ

Чөлөөт цагаараа сургалтад сууж амждаггүй ажилтнууддаа зориулан балет, йога, гитарын сургалтуудыг хөнгөлөлттэй үнээр ажлын байран дээр хичээллүүлж байна.

“Ойн булаг” зуслан

Ажилтнуудыг гэр бүлийн хамтаар зуны саруудын хугацаанд тохилог, орчин сайтай зусландаа гарах боломжийг жил бүр олгодог билээ. 2020 оны хувьд нийт 140 ажилтан гэр бүлийн хамтаар зусландаа гарсан байна.



Тогтвортой санхүүжилтийн чадавх бэхжүүлэх сургалт

Голомт банк тогтвортой санхүүжилтийн чадавх бэхжүүлэх ажлын хүрээнд 2020 онд дараах 3 чиглэлээр системтэй цогц мэдлэгийг ажилтнууддаа хүргэн ажиллалаа. Үүнд:

- Нийт ажилтнуудад тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилтийн ач холбогдлыг таниулах
- Сургалт хөгжлийн үйл ажиллагаа
- Ажилтнуудын дундах арга хэмжээ болон уриалга

тогтвортой
хөгжлийн
тайлан
2020

Нийт ажилтнуулын 84 хувийг Тогтвортой санхүүжилтийн сургалтад дараах байдлаар хамруулав. Үүнд:

Ногоон санхүүжилтийн онлайн сургалт
1328 ажилтан

Зээлийн үйл ажиллагааны шинэ ажилтан бэлтгэх сургалт
51 ажилтан

ТоC холбоотой хамтарсан онлайн сургалт
173 ажилтан

ТоC ба байгаль орчин нийгмийн эрдээлийн үнэлгээ
11 удирдах ажилтан

Тогтвортой хөгжил ба Тогтвортой санхүүжилт сургалт
34 ажилтан

Тогтвортой хөгжил, Тогтвортой санхүүжилтийн ач холбогдлыг таниулах, түгээх зорилгоор нийт 38 постер мэдээллийг дотоод сүлжээ, ажилтны компьютерийн дэлгэц солих, ажилтнуудын сошиал хуудсуудаар дамжуулан хүргэлээ.

Мөн ТоC холбоотой хамтран 1 удаагийн подкаст, банкны дотоод ТоC-ийн ажлын хэсгүүдтэй хамтарсан 3 видео сургалтыг бүтээж ажилтнуудад хүргэлээ.

Залуу үедээ ТоС-ийг таниулах ажлууд

- Ажилтны хүүхдүүдийн дунд дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр бүтээл урлах уралдааныг амжилттай зохион байгуулав.
- Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт 100 оюутны суурь шалгуураар “Тогтвортой хөгжилд залуусын оролцоо” болон “Цэнхэр алт усаа хайлралаа” сэдвүүдээр эсээний уралдаан зохион байгуулав.

Байгалийн нөөцийн зохистой хэрэглээ



Тогтвортой хөгжлийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлахын тулд дотоод үйл ажиллагаандаа системтэй арга хэмжээнүүдийг аван ажиллаж байна. Бидний гол анхаарах зүйл бол нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах явдал юм.

Цахилгаан эрчим хүчний хэмнэлт

Эрчим хүчний хэрэглээ нь хүлэмжийн хийн ялгарлыг их хэмжээгээр нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтийг бий болгодог. Голомт банк цахилгаан эрчим хүчийг хэмнэх үүднээс дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.

Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилууллаа

Голомт банк Гуравдугаар оффистоо сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилуулан туршиж байгаа бөгөөд Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжийн хүчин чадал нь сард 1080 квт буюу тухайн оффисын хэрэглээний 6%-ийг бууруулах тооцоотой байна.



37

Цахилгаан бага зарцуулдаг лед гэрэл сонгон ашигладаг боллоо

Оффисын гэрлийг солих шаардлага гарвал цахилгаан бага зарцуулдаг лед гэрлийг сонгон хэрэглэж байна. Гэрэл солиулах 390 хүсэлтийн дагуу шинээр сольсон бүх гэрлээ лед гэрлээр сольсон. Мөн шинээр хийгдэж байгаа барилгын засварын ажлуудад зөвхөн лед гэрэл суурилуулж байна.

Барилгын дулаан алдагдлыг бууруулж эхэллээ

Барилгын дулаан алдагдах нь барилга элэгдэж хорогдох, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тав тухгүй байдлаас гадна эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлдэг билээ. Тиймээс Голомт банк салбаруудын дулаан алдагдлыг бууруулах зорилгоор дотор болон гадна цонхонд амлагаа, үүдний тамбор хийсэн. Уг ажлын хүрээнд 2020 онд 7 салбарын дотор цонхонд амлагаа, 5 салбарт үүдний тамбор, 1 салбарт гадна цонхны амлагаа хийгээд байна.



Усны хэмнэлт

Суултуурт усны эзлэхүүн багасгагч суурилуулснаар өмнөх 6 сарын дундажтай харьцуулахад 10%-ийн усны хэмнэлт гарлаа.

Цаасны хэмнэлт

Цаасны зохистой хэрэглээг зохицуулсан “Хэвлэх хувилах машины хэрэглээний стандарт” боловсруулж батлууллаа.

Олон үйлдэлт хувилах машин ашиглаж эхэллээ

Хувилагч төхөөрөмжөөс ялгарч буй хэт ягаан тuya нь ажилтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс олон жижиг принтерийн тоог багасгаж, 1 олон үйлдэлт хувилагч төхөөрөмж ашиглаж байна. Олон үйлдэлт хувилах машиныг нэвтрүүлсэн нэгжүүдийн цаасны хэрэглээ 20%-аар буурсан.

Мөн хэвлэх төхөөрөмжийн хорыг заавал 2 удаа дахин цэнэглүүлж хэрэглэдэг болсноор тайлант хугацаанд 660 хорыг дахин цэнэглэн ашигласан.

Тэргэнцэрийн налуу зам

Тэргэнцэртэй иргэд зорчих боломжтой налуу замыг 1 оффис, 1 салбарт хийж тохижууллаа.

Хуванцар хэрэглээнээс татгалзаж эхэллээ

Нэг удаагийн аяга, халбага, соруул, салфетка, гялгар уутны хэрэглээ нь нийт хог хаягдлын тал хувийг эзэлж байгаа бөгөөд хуванцар хаягдлын ердөө 9%-ийг л дахин боловсруулах боломжтой байдаг байна. Голомт банк оффис дээрх пластик хэрэглээгээ бууруулахын тулд хурал уулзалт, сургалтуудаа нэг удаагийн хэрэглэл ашиглалгүй, шилэн сав, шилэн стакан ашиглах арга хэмжээг аван ажиллаж байна. Төвийн 5 оффист нийт 44 шилэн сав, 323 шилэн аяга байршуулаад байна.

Хог хаягдлаа ангилдаг боллоо

Хог хаягдлыг бууруулах зорилгоор оффисуудад ангилалтай хогийн сав байршуулан ажилтнуудад хог хаягдлыг ангилах зааварчилгаа танилцуулга өгч, ангилуулж байна. Ангилсан хог хаягдлаа “Монголын хог хаягдал дахин боловсруулах үндэсний хороо”-ны дэргэдэх “Өнгө нэм” төсөлтэй хамтран тээвэрлэлт хийлгүүлж дахин боловсруулах үйлдвэрт тушааж байгаа ба Төвийн 6 оффис, Улаанбаатар хотын 52 салбарт нийт 104 хос ангилалтай хогийн сав байршуулан цаас, хуванцар, гялгар уут, шил, лааз гэсэн ангилалтайгаар тээвэрлүүлж байна.



Ногоон зул сар

“Ногоон зул сар” оффис чимэглэлийн уралдааныг банкны хэмжээнд зохион байгуулж 3R /Reduce, Reuse, Recycle/ зарчмын хүрээнд байгаль эх дэлхийдээ ээлтэйгээр оффисоо чимэглэлээ.



“Мод тарих” чалленж

2020 оны 5 сарын 23-аас эхлэн Голомт банкны хамт олны дунд “Мод тарих” уриалга зарлаж, нийт 336 модыг байгаль эх дэлхийдээ үрслүүлсэн ба банкны 28 нэгжийн 1000 гаруй ажилтан сайн дураар уриалгад нэгдлээ.

Худалдан авалтын сонголтоо ногоон болголоо

Худалдан авалтын гэрээ болон Худалдан авалтын журамд тогтвортой санхүүжилтийн заалт оруулж байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгодог боллоо. Үүний хүрээнд шинэ жилээр харилцагчийн бэлгэнд дахин боловсруулсан болон эко, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бэлтгэлээ.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин “Мойл”, “Хунчир” брэндийн бүтээгдэхүүнийг харилцагчийн бэлгэнд бэлтгэсэн ба сав баглаа боодлыг нь “Үр минь” брэндийн даавуун тор болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж нар хаягдал сонины цаасаар сүлжиж урласан сагсанд хийллээ.



тогтвортой
хөгжлийн
тайлан
2020

Банкны худалдан авдаг бараа материалын байгаль орчинд ээлтэй байдлын судалгаа хийсэн ба бичиг хэргийн 28 төрлийн материалаас 5 нь эко, 12 нь эко бүтээгдэхүүнээр солих боломжтой, 11 нь эко бүтээгдэхүүнээр солих боломжгүй гэсэн үр дүн гарлаа. Банкны худалдан авдаг тоног төхөөрөмжийн байгаль орчинд ээлтэй байдлын судалгаа хийснээр 17 оффисын тоног төхөөрөмжөөс 12 нь эрчим хүчний хэмнэлттэй гэсэн үр дүн гарчээ.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЖИЛТ, ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны Тогтвортой хөгжлийн ололт амжилтууд

ТоС-ийн “А” үнэлгээ авч салбартаа дээгүүр жагслаа



2016 оноос эхлэн ТоС Холбооноос гишүүн банкнууддаа ТоС-ийн хэрэгжилтийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлж ирсэн бөгөөд 2020 онд уг үнэлгээний аргачлал нь илүү нарийвчлагдаж Монгол Улсын ТоС-ийн зарчмууд, салбарын удирдамжууд, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) жишиг үнэлгээний аргачлал, Уур Амьсгалын Ногоон Сангийн (УАНС) хөрөнгө оруулалтын шаардлага болон бусад олон улсын сайн туршлагын дагуу боловсруулагдсан юм. Үнэлгээг хийхдээ Тос Холбоо, Монголбанк болон ОУСК-ийн төлөөллөөс бүрдсэн үнэлгээний баг банкны үйл ажиллагаатай очиж танилцан, ярилцлага хийн хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтыг хийсэн билээ.

41

Голомт банк уг үнэлгээгээр энэ онд “А” үнэлгээ авч салбартаа дээгүүр жагссан амжилт гаргалаа. Үнэлгээний үр дүнд банкны байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага сайн, ногоон төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийн болон хүний нөөцийн чадамж сайн үнэлэгдсэн бөгөөд ТоС-ийн бодлого, сургалт хөгжил зэрэг шалгуурт мөн өндөр оноо авсан юм. Голомт банкны 2019 оны ТоС үнэлгээ В+ байсан бөгөөд жил бүр ТоС-ийн хэрэгжилтийн чанарыг сайжруулан ажиллаж байна.

2020 оны “Онцлох ТоС Банк”-аар тодорлоо

“Монголын Тогвортой Санхүүжилтийн Хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк болон Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) Холбооноос жил бүр ТоС-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой ахиц дэвшил, амжилт гаргасан банкнуудыг тодруулдаг билээ. 2020 оны “Онцлох ТоС Банк”-аар Голомт банк шалгарч байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, ногоон зээл, ТоС-ийн сургалт хөгжил зэрэг ажлуудаараа манлайлан шалгарлаа.

Энэ жилийн уралдааны хүрээнд Олон Улсын Санхүүгийн Корпораци хамтран зохион байгуулж шалгаруулалтыг ОУСК-ийн санал, шалгуурын дагуу явуулсан нь банкнуудын хувьд шинэлэг байлаа.



Голомт банк нь 2020 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын системээ бүрэн шинэчилж, зээлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тухайн салбарын онцлогийг авч үзэн нарийвчлан үнэлж, байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг бууруулах зөвлөмж шаардлагуудыг харилцагчдадаа тавьж ажилласан нь шалгуурын чухал үзүүлэлт байлаа. Түүнчлэн 2020 оны онцлоо ажлуудад банкны дотоод үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд

ээлтэй байлгах үүднээс хог хаягдлыг дахин ангилах системтэй болж ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах төвүүдэд хүргүүлдэг болсон, цахилгааны болон усны хэрэглээг бууруулсан болон тогтвортой санхүүжилтийн сургалт хөгжлийн хүрээнд нийт 72 удаагийн 3259 хүн цагийн сургалт орсон зэрэг ажлуудыг зохион байгуулагчид онцоллоо.

2021 оны Тогтвортой хөгжлийн үндсэн төлөвлөгөө

Тогтвортой хөгжлийн хүрээнд 2021 онд бид дараах гол ажлуудыг төлөвлөж байна. Үүнд:

- Голомт банкны зээлийн багцын түвшинд хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, жил бүр бууруулах зорилт тавин ажиллах. Ингэхдээ өөрийн харилцагчдадаа Парисын хэлэлцээрийн зорилтууд болон “Монгол Улсын Үндэсний Зорилtot Хувь Нэмэр”-ийн хүрээнд чухал мэдлэг олгох, харилцагчдын бизнесийн үйл ажиллагаанаас ялгарч байгаа хүлэмжийн хийн шууд ялгарлыг бууруулахад хамтарч ажиллах, банкны зүгээс үзүүлэх боломжтой бүхий л санхүүгийн болон техникийн зөвлөгөө үйлчилгээгээр хангах.
- Ногоон зээлийн багцын хэмжээг өмнөх жилтэй харьцуулахад 5%-аар нэмэгдүүлэх. Үүний хүрээнд харилцагчдын хэрэгцээнд нийцсэн, байгаль орчин, нийгмийн ээрэг нөлөөтэй ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгох, ногоон төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлэн ажиллах.
- Голомт банк нь ТоC хөтөлбөрийг үүсгэн байгуулагдсан цагаас хойш дэмжин ажиллаж, анх 2016 онд ТоC Манлайлагч байгууллагаар сонгогдон ажиллаж байсан бөгөөд 2021 оны ТоC Манлайлагч банкаар Голомт банк дахин сонгогдож ирэх жилийн тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх ажилд манлайлан ажиллахаар боллоо.
- Банкны нийт ажилтнуудад тогтвортой санхүүжилтийн системтэй, цогц мэдлэг хүргэх. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ, зээлийн багцын хүлэмжийн хийн ялгарал тооцоолох зэрэг илүү техникийн сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- Банкны дотоод үйл ажиллагааны нөөцийн хэмнэлтийг нэмэгдүүлэх. Усны хэмнэлт бий болгох технологийн шийдлүүдийг оффисуудад суурилуулах.
- Тогтвортой хөгжлийн тайлагналыг сайжруулах. Олон улсын стандартын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тайлагнах.



www.golomtbank.com